



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай Нийтлэг үйлчилгээ Улсын төсөвт үйлдвэрийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/007/НА-СТА- ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот	2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: М.Атарцэцэг Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn Аудитор: Б.Мөнхболд Утас: 99041008 Цахим хаяг: munkhboldbo@audit.gov.mn
--	---------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025.03.17

№

112

танай _____ -ны № _____ -г

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Говь-Алтай Нийтлэг үйлчилгээ" УТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнөөс бараа үйлчилгээний зардлыг 68,595.4 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан,
- Аймгийн Засаг даргын Тамгын газраас нэмж олгосон 50,00.0 мянган төгрөгөөр үр тариа бордоо худалдан авахаар гэрээ байгуулж санхүүжүүлсэн боловч гэрээний дагуу хийсэн ажил тодорхойгүй, анхан шатны баримтаар нотлохгүй байна.

8225020316

Асуудлыг онцолсон хэсэг

Туульсын хаан “ЖАНГАР” тууль хайлах арга хэмжээ, Дөргөн нуурын чуулга уулзалт, Ховд мөнгөн шагшуурга, “Бурхан буудай” уулын төрийн тахилга, +80 хөтөлбөр зэрэг арга хэмжээний зохион байгуулалтад оролцсон байна. Тус байгууллага нь 2024 оны аймгийн Тэргүүний хамт олноор шалгарсан байна.

Аудитын гол асуудал

Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 151,758.0 мянган төгрөгөөр өссөн нь төрийн албан хаагчдын цалин, хөлс нэмэгдсэн, мөн дээрх арга хэмжээнүүдийг зохион байгуулсантай холбоотой байна.

Тайлант онд Солонго дулааны станц УТҮГ-аас 21,400.0 мянган төгрөгийн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас 11,623.0 мянган төгрөгийн, нийт 33,023.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 5 зорилт, 35 арга хэмжээний хэрэгжилтийг 94.9 хувиар үнэлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>67,328,001.99</u>	<u>40,742,881.19</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	22,962,688.09	17,041.29
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	22,962,688.09	17,041.29
3121	Төгрөг	22,962,688.09	17,041.29
31213	Арилжааны банк дахь харилцах	22,962,688.09	17,041.29
33	АВЛАГА	20,857,849.90	20,550,649.90
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	20,857,849.90	20,550,649.90
35	БАРАА МАТЕРИАЛ	23,507,464.00	20,175,190.00
354	Хангамжийн материал	23,507,464.00	20,175,190.00
35420	Аж ахуйн материал	22,501,464.00	19,460,690.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,006,000.00	714,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,066,946,055.10</u>	<u>6,996,877,313.68</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,066,946,055.10	6,996,877,313.68
392	Биет хөрөнгө	7,050,188,055.09	6,980,119,313.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,511,265,663.00	4,511,265,663.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(58,460,005.93)	(133,297,075.80)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	30,760,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(20,060,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	52,498,468.00	49,539,468.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(34,479,746.98)	(37,366,418.52)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,973,247.00	4,973,247.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,305,747.00)	(4,391,747.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,578,696,177.00	2,578,696,177.00
393	Биет бус хөрөнгө	-	-
39303	Бусад биет бус хөрөнгө	16,758,000.00	16,758,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>7,134,274,057.09</u>	<u>7,037,620,194.87</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>7,134,274,057.09</u>	<u>7,037,620,194.87</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	7,134,274,057.09	7,037,620,194.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	249,575,633.26	249,575,633.26
51101	Өмч: - төрийн	249,575,633.26	249,575,633.26
512	Хуримтлагдсан үр дүн	6,489,513,046.78	6,392,859,184.56
51210	Өмнөх үеийн үр дүн	6,489,513,046.78	6,489,513,046.78
51220	Тайлант үеийн үр дүн	-	(96,653,862.22)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	395,185,377.05	395,185,377.05
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>7,134,274,057.09</u>	<u>7,037,620,194.87</u>

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12-сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	607,549,525.00	759,307,485.00
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	0	0
3	Нийт ашиг (алдагдал)	607,549,525.00	759,307,485.00
8	Бусад орлого	7,068,920,369.00	33,023,000.00
11	Санхүүгийн зардал	624,634,888.04	888,984,347.22
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0	0
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	7,051,835,005.96	(96,653,862.22)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	7,051,835,005.96	(96,653,862.22)
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	7,051,835,005.96	(96,653,862.22)
24	Орлогын нийт дүн	7,051,835,005.96	(96,653,862.22)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2024 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	249,575,633.26	395,185,377.05	(207,098,216.93)	437,662,793.38
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	(165,839,340.41)	(165,839,340.41)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	(189,384,401.84)	(189,384,401.84)
2024 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	249,575,633.26	395,185,377.05	6,489,513,046.78	7,134,274,057.09
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	(96,653,862.22)	(96,653,862.22)
2024 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	249,575,633.26	395,185,377.05	6,392,859,184.56	7,037,620,194.87

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	621,303,781.00	764,523,607.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	28,643,375.00	30,984,285.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	651,484.00	888,922.00

1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	578,553,450.00	672,255,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	13,455,472.00	60,393,400.0
1.2	Мөнгөн зарлага (-)	607,958,996.56	806,354,253.80
1.2.1	Ажиллагчдад төлсөн	379,062,249.00	533,925,054.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	91,263,341.57	132,340,360.80
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	72,188,827.00	131,445,545.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	22,615,382.11	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	5,020,341.88	240,128.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	173,950.00	220,566.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	37,634,905.00	8,182,600.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	13,344,784.44	13,344,784.44
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0	0
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0	18,885,000.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0	0
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0	0
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	13,344,784.44	(22,945,646.80)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,617,903.65	22,962,688.09
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	22,962,688.09	17,041.29

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Тайлант оны			
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үндсэн үйл ажиллагааны орлого /санхүүжилт/	610,000,000.00	728,595,400.00	(118,595,400.00)	119.44
Туслах үйл ажиллагааны орлого	25,000,000.00	31,873,207.00	(6,873,207.00)	127.49
Бусад орлого	-	4,055,000.00	(4,055,000.00)	-
ОРЛОГО	635,000,000.00	764,523,607.00	(129,523,607.00)	120.40
1.3 Нийт ашиг	-	(124,460,740.22)	(253,984,347.22)	140.00
Санхүүгийн зардал	635,000,000.00	888,984,347.22	(253,984,347.22)	140.00
1.4.20 Үйл ажиллагааны зардлын дүн	635,000,000.00	624,634,888.04	182,251,911.04	141.20
1.5 Үйл ажиллагааны ашиг /алдагдал/	-	(124,460,740.22)	(124,460,740.22)	
Үндсэн бус үйл ажиллагаа				
ҮХ борлуулсны олз, гарз				
3. Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/		(124,460,740.22)	(124,460,740.22)	
Татвар төлөх ашиг /алдагдал/		(124,460,740.22)	(124,460,740.22)	
4. Татварын дараах ашиг /алдагдал/		(124,460,740.22)	(124,460,740.22)	

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар залруулга хийгдээгүй.

Залруулагдаагүй нийт 118,595.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон нь ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 118,595.4 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрч, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлсэн.

3.2 Албан шаардлага

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнөөс бараа үйлчилгээний зардлыг 68,595.4 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөгөөр баталсан зардлын хүрээнд хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газраас нэмж олгосон 50,00.0 мянган төгрөгөөр үр тариа бордоо худалдан авахаар гэрээ байгуулж санхүүжүүлсэн боловч гэрээний дагуу хийсэн ажил тодорхойгүй, анхан шатны баримтаар нотлохгүй байгааг нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх"; 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах"; гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны нотлох баримтгүйгээр зарцуулсан хөрөнгийн зарцуулалтад дотоод хяналт шалгалт хийж, биелэлтийг ирүүлэхийг Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны даргад албан шаардлага хүргүүлсэн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилгот түвшний төлөвлөгөөнөөс бараа үйлчилгээний зардлыг 68,595.4 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.	1	68,595.4	-	-	1	68,595.4	-	-	-	-	-	-
Аймгийн Засаг даргын Тамгын газраас нэмж олгосон 50,000.0 мянган төгрөгөөр үр тариа бордоо худалдан авахаар гэрээ байгуулж санхүүжүүлсэн боловч гэрээний дагуу хийсэн ажил тодорхойгүй, анхан шатны баримтаар нотлохгүй байна.	1	50,000.0	-	-	1	50,000.0	-	-	-	-	-	-
Нийт дүн	2	118,595.4	-	-	2	118,595.4	-	-	-	-	-	-



Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтий	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
A	1	2	3	4	5	7	8	9	10	
1	ТШЗ		1				1			
	НИЙТ		1				1			

